



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙДЫН ТУШААЛ

2020 оны 04 сарын 14 өдөр

Дугаар А/79

Улаанбаатар хот

Хуулийн хэрэгжилтийг сайжруулах
тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Шилэн дансны тухай хуулийн 6,7,10 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл байршуулах хуваарийг 1 дүгээр, Зам, тээврийн хөгжлийн яамны шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл байршуулах хуваарийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулах мэдээллийг тогтоосон хугацаанд үнэн, зөв мэдээлэх, мэдээллийн нэгдсэн тайланг улирал бүрийн дараа сарын 15-ны дотор Сангийн яаманд цахимаар, Зам, тээврийн хөгжлийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт албан бичгээр тайлагнаж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайдын шилэн дансны цахим бүртгэлд хамаарах байгууллагууд, Сайдын багцын хөрөнгө оруулалтаар төсөл, хөтөлбөр, арга хэмжээ хэрэгжүүлж, ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа байгууллага, аж ахуйн нэгжийн дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж, тайлагнах мэдээлэл, арга зүйгээр хангах, шилэн дансны хөтлөлтийн үнэлгээний жилийн эцсийн тайланг дараа оны 4 дүгээр сарын 01-ний дотор Засгийн газрын хэрэг эрхлэх газарт тайлагнаж ажиллахыг яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /М.Энхболд/-т үүрэг болгосугай.

4. Шилэн дансны тухай хууль, тогтоомж зөрчсөн албан тушаалтанд, гаргасан зөрчлийн байдлыг харгалзан сахилгын шийтгэл ногдуулж, хариуцлага тооцож ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /С.Батболд/, харьяа байгууллагуудын дарга, захирал нарт даалгасугай.

5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 102 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Б.ЭНХ-АМГАЛАН